

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 27 дугаар цэцэрлэг 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/86/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Дархан-Уул аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:
Утас: 70378845
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 70373089
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Ч.Гантулга
Утас: 99372297
Цахим хаяг: munguntsetsegz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 124

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 27 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 27 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд Дархан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 6,684.0 мянган төгрөгийн хүүхдийн сэтгэхүй хөгжүүлэх тоглоом, 3,033.9 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж болон 4 ш компьютерийг тус тус хүлээн авч, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны А/36 тоот тушаалын дагуу бүртгэж, санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 129,872.5 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 20 хувиар өссөн байна.

4526050076

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан сумын 27 дугаар цэцэрлэгийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 14 зорилтын хүрээнд 43 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 98 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр аймгийн боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлж үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	173,823,879.72	98,746,397.48
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	143,431,325.22	27,889,575.08
312	Банкинд байгаа	143,431,325.22	27,889,575.08
3121	Төгрөг	143,431,325.22	27,889,575.08
31211	Төрийн сангийн харилцах	143,431,325.22	27,889,575.08
35	БАРАА МАТЕРИАЛ	30,392,554.50	70,856,822.40
354	Хангамжийн материал	30,392,554.50	70,856,822.40
35410	Бичиг хэргийн материал	543,300.00	1,704,500.00
35420	Аж ахуйн материал	1,580,000.00	18,416,000.00
35460	Хүнсний материал	5,774,634.50	8,184,632.40
35470	Бусад хангамжийн материал	22,494,620.00	42,551,690.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,309,208,161.82	1,287,329,232.18
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,309,208,161.82	1,287,329,232.18
392	Биет хөрөнгийн дүн	1,171,408,161.82	1,149,529,232.18
39201	Барилга байгууламж	1,229,192,772.00	1,229,192,772.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(145,880,170.59)	(166,366,716.75)
39205	Машин тоног төхөөрөмж	67,084,606.30	78,704,606.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,357,521.55)	(24,147,275.43)
39207	Тавилга, эд хогшил	46,442,226.64	47,322,226.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,792,301.36)	(20,617,290.84)
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,776,400.00	12,776,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,057,849.62)	(7,335,489.74)
393	Биет бус хөрөнгийн дүн	137,800,000.00	137,800,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	137,800,000.00	137,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,483,032,041.54	1,386,075,629.66
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,483,032,041.54	1,386,075,629.66
51	Засгийн газрын хувь оролцоо	1,483,032,041.54	1,386,075,629.66
511	Засгийн газрын оруулсан капитал	137,800,000.00	137,800,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,345,232,041.54	1,248,275,629.66
51210	Өмнөх үеийн үр дүн	1,345,232,041.54	1,345,232,041.54
51220	Тайлант үеийн үр дүн	-	(96,956,411.88)
6	ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН	1,483,032,041.54	1,386,075,629.66

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	855,649,200.00	860,116,270.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,297,500.00	60,953,670.00
120	Нийтлэг татварын бус орлого	25,297,500.00	60,953,670.00
1200045	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,549,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	21,748,500.00	12,500,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	48,453,670.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	830,351,700.00	799,162,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	785,953,800.00	761,100,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,397,900.00	38,062,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,397,900.00	38,062,400.00
2	Үйл ажиллагааны зардал	785,074,807.56	957,072,681.88
21	Урсгал зардал	785,074,807.56	957,072,681.88
210	Бараа, үйлчилгээний зардал	766,623,243.82	955,442,013.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	537,206,452.33	689,819,270.14
210101	Үндсэн цалин	352,571,958.33	435,746,986.55
210102	Нэмэгдэл цалин	138,872,981.00	190,788,440.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,818,000.00	24,065,224.00
210104	Урамшуулал	18,926,300.00	35,242,283.39
210105	Гэрээтийн цалин	25,017,213.00	3,976,336.00
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	74,356,100.00	85,944,300.00
210201	Тэтгэврийн даатгалын	50,562,800.00	58,296,200.00
210202	тэтгэмжийн даатгалын	5,947,600.00	6,912,000.00
210203	ҮОМШӨ-ий даатгалын	2,974,300.00	3,456,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын	2,974,300.00	3,456,000.00
210205	ЭМ-ийн даатгалын	11,897,100.00	13,824,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,018,736.26	26,431,732.00
210301	Гэрэл цахилгааны зардал	7,034,578.06	9,523,795.50
210302	Түлш, халаалтын зардал	6,908,059.84	8,635,221.50
210303	Цэвэр бохир усны зардал	7,076,098.36	8,272,715.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,422,700.00	18,974,350.00
210401	Бичиг хэргийн зардал	7,016,800.00	1,310,800.00
210403	шуудан холбоо	257,400.00	2,150,000.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх	148,500.00	2,700,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	12,813,550.00
2105	Нормативт зардал	65,388,276.00	74,155,982.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	123,390.00	1,350,000.00
210502	Хоол, хүнс	65,264,886.00	72,805,982.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,351,500.00	10,198,000.00
210604	Урсгал засварын зардал	19,351,500.00	10,198,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	715,800.00	-

210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	715,800.00	-
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	41,163,679.23	49,918,379.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,445,400.00	7,878,550.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,500,000.00	7,660,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,218,279.23	34,378,929.64
213	Урсгал шилжүүлэг	18,451,563.74	1,630,668.00
	Бусад урсгал шилжүүлэг	14,572,400.00	-
	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	14,572,400.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,879,163.74	1,630,668.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,879,163.74	1,630,668.00
3	Үйл ажиллагааны үр дүн	70,574,392.44	(96,956,411.88)
5	Үйл ажиллагааны нийт үр дүн	70,574,392.44	(96,956,411.88)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	830,351,700.00	799,162,600.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	830,351,700.00	799,162,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	785,953,800.00	761,100,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	785,953,800.00	761,100,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,397,900.00	38,062,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,397,900.00	38,062,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	759,421,817.33	914,704,350.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	759,421,817.33	914,704,350.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	740,970,253.59	913,073,682.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	537,145,252.33	689,429,270.14
210101	Үндсэн цалин	366,879,934.33	435,356,986.55
210102	Нэмэгдэл	121,207,805.00	190,788,440.20
210103	Хоол унаа хөнгөлөлт	1,818,000.00	24,065,224.00
210104	Урамшуулал	22,222,300.00	35,242,283.39
210105	Гэрээт ажлын хөлс	25,017,213.00	3,976,336.00
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх	74,356,100.00	85,944,300.00
210201	Тэтгэврийн даатгалын	50,562,800.00	58,296,200.00
210202	Тэтгэмжийн даатгалын	5,947,600.00	6,912,000.00
210203	ҮОМШӨ-ий даатгалын	2,974,300.00	3,456,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын	2,974,300.00	3,456,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын	11,897,100.00	13,824,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,018,736.26	26,431,732.00
210301	Гэрэл цахилгааны зардал	7,034,578.06	9,523,795.50
210302	Түлш, халаалтын зардал	6,908,059.84	8,635,221.50
210303	Цэвэр бохир усны зардал	7,076,098.36	8,272,715.00
2105	Нормативт зардал	66,395,775.00	75,215,980.00
210502	Хоол, хүнс	66,395,775.00	75,215,980.00
2106	Эд хогшил урсгал засвар	19,500,000.00	10,198,000.00
210604	Урсгал засвар	19,500,000.00	10,198,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	715,800.00	2,150,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	715,800.00	2,150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,838,590.00	23,704,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,367,390.00	16,043,500.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	7,471,200.00	7,660,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,451,563.74	1,630,668.00
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	14,572,400.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,879,163.74	1,630,668.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,879,163.74	1,630,668.00
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	70,929,882.67	(115,541,750.14)
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн	(7,846,600.00)	-
22	Хөрөнгийн зардал	(7,846,600.00)	-
2200	Дотоод эх үүсвэрээр	(7,846,600.00)	-
223001	Бусад хөрөнгө	(7,846,600.00)	-
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	63,083,282.67	(115,541,750.14)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	80,348,052.55	143,431,325.22
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	143,431,325.22	27,889,575.08

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний мөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
A	1	2	3	4
2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	137,800,000.00	-	1,274,657,649.10	1,412,457,649.10
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
УХ-ийн өсөлт, бууралт	-	-	-	-
УХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн			70,574,392.44	70,574,392.44
2024 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	137,800,000.00		1,345,232,041.54	1,483,032,041.54
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
УХ-ийн өсөлт, бууралт	-	-	-	-
УХ-ийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн			(96,956,411.88)	(96,956,411.88)
2025 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	137,800,000.00		1,248,275,629.66	1,386,075,629.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	799,162,600.00	797,531,912.00	(1,630,688.00)	99.8
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	761,100,200.00	761,100,200.00	-	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	761,100,200.00	761,100,200.00	-	100
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	38,062,400.00	36,431,712.00	(1,630,688.00)	95.72
132001	Орон нутгийн төсвөөс	38,062,400.00	36,431,712.00	(1,630,688.00)	95.72
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	143,431,325.22	-	(143,431,325.22)	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	143,431,325.22	-	(143,431,325.22)	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	942,593,925.22	797,531,912.00	(145,062,013.22)	84.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	933,292,200.00	913,073,682.14	(20,218,517.86)	97.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	933,292,200.00	913,073,682.14	(20,218,517.86)	97.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	691,202,900.00	689,429,270.14	(1,773,629.86)	99.74
210101	Үндсэн цалин	430,762,000.00	435,356,986.55	4,594,986.55	101.07
210102	Нэмэгдэл	233,439,000.00	190,788,440.20	(42,650,559.80)	81.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт		24,065,224.00	24,065,224.00	
210104	Урамшуулал	27,001,900.00	35,242,283.39	8,240,383.39	130.52
210105	Гэрээт ажлын хөлс	-	3,976,336.00	3,976,336.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,944,300.00	85,944,300.00	-	100
210201	Тэтгэврийн даатгал	58,296,200.00	58,296,200.00	-	100
210202	Тэтгэмжийн даатгал	6,912,000.00	6,912,000.00	-	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,456,000.00	3,456,000.00	-	100
210204	Ажилгүйдлийн даатгал	3,456,000.00	3,456,000.00	-	100
210205	Эрүүл мэндийн даатгал	13,824,100.00	13,824,100.00	-	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,521,700.00	26,431,732.00	(12,089,968.00)	68.62
210301	Гэрэл, цахилгаан	13,290,000.00	9,523,795.50	(3,766,204.50)	71.66
210302	Түлш, халаалт	12,500,500.00	8,635,221.50	(3,865,278.50)	69.08
210303	Цэвэр, бохир ус	12,731,200.00	8,272,715.00	(4,458,485.00)	64.98
2104	Хангамж, бараа материалын зардал	-	2,150,000.00	2,150,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	2,150,000.00	2,150,000.00	-
2105	Нормативт зардал	78,562,600.00	75,215,980.00	(3,346,620.00)	95.74
210502	Хоол, хүнс	78,562,600.00	75,215,980.00	(3,346,620.00)	95.74
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	10,198,000.00	198,000.00	101.98
210604	Урсгал засвар	10,000,000.00	10,198,000.00	198,000.00	101.98
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,962,200.00	-	(3,962,200.00)	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,962,200.00	-	(3,962,200.00)	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,098,500.00	23,704,400.00	(1,394,100.00)	94.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,437,600.00	16,043,500.00	(1,394,100.00)	92.01
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,660,900.00	7,660,900.00	-	100
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	933,292,200.00	913,073,682.14	(20,218,517.86)	97.83

31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	143,431,325.22	143,431,325.22	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	27,889,575.08	27,889,575.08	-
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО			-	
3	Төсвийн байгууллага	1	1	-	100
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	31	28	(3.00)	90.32
6	Удирдах ажилтан	1	1	-	100
7	Гүйцэтгэх ажилтан	23	20	(3.00)	86.96
8	Үйлчлэх ажилтан	7	7	-	100

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 3,088.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлснээс биелэлт 100 хувийн хэрэгжилттэй байна.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	тоо	дүн	тоо	дүн	хувь
Зөвлөмж	1	-	1	-	100%
Албан шаардлага	1	3,088.0	1	3,088.0	100%
Нийт дүн	2	3,088.0	1	3,088.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

аудитаар нийт 6,821.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул алдаа зөрчлийг таслан зогсоох 6,821.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

5.2.1.Илрүүлэлт: Тус цэцэрлэгийн эрхлэгч Ж.Батзаяа нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,144.0 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна", 27.6-д "Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална", Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В хэсэгт "Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтанд хавсран хариуцуулна. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.2.Илрүүлэлт: Тус цэцэрлэгийн нягтлан бодогч П.Алтанчимэгд Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, цэцэрлэгийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

эрхлэгчийн 2025 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн А/13 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан тул нэг сарын үндсэн цалинг 3 дахин нэмэгдүүлж, 4,677.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-д "Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай", "Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.8-д "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт				Албан шаардлага		Зөвлөмж		Харууцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	/мянган төгрөгөөр/		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Харууцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус цацэрлэгийн эрхлэгч Ж.Батзаяа нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал харууцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 1,608,000.00 төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.	1	2,144.0	-	-	1	2,144.0	-	-	-	-	-	-	-	
Тус сургуулийн нягтлан бодогч П.Алтанчимэгд Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, цацэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн Б/31 дүгээр тушаалыг тус тус үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан тул нэг сарын үндсэн цалинг 3 дахин нэмэгдүүлэн 4,677,000.00 төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна.	1	4,677.0	-	-	1	4,677.0	-	-	-	-	-	-	-	
Дүн	3	6,821.0	-	-	2	6,821.0	-	-	-	-	-	-	-	



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 он 02 сар 25 өдөр

Дугаар 38/01

Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дархан-Уул аймгийн Дархан сумын 27 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч Ж.Батзаяа нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,144,000.00 төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна", 27.6-д "Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална", Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В хэсэгт "Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтанд хавсран хариуцуулна. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Төсвийн тухай хууль болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлэх
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дархан сумын 27 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Ж.Батзаяа, нягтлан бодогч П.Алтанчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

"ЦЭСБ АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.ЦЭРЭННАДМИД

"ЦЭСБ АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Ч.ГАНТУЛГА

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

4526090341



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 он 02 сар 25 өдөр

Дугаар 39/02

Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дархан-Уул аймгийн Дархан сумын 27 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус цэцэрлэгийн нягтлан бодогч П.Алтанчимэгд Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн Б/17 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан тул нэг сарын үндсэн цалинг 3 дахин нэмэгдүүлж, 4,677,000.00 төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-д "Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай", "Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.8-д "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Төсвийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлэх
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дархан сумын 27 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Ж.Батзаяа, нягтлан бодогч П.Алтанчимэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНӨ

"ЦЭСБ АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.ЦЭРЭННАДМИД

"ЦЭСБ АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Ч.ГАНТУЛГА

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

4525090344